

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ГЕГ-ын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/128/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ	4-5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6-13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	144-18
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19-20
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21-22
5.1 Албан шаардлага.....	21-22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ГЕГ-ЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ӨНӨБОЛД ТАНАА**

2025.02.21 № САА-2025/128/ТА-ТА-743
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ГЕГ-ын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

2024 онд “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг боомтуудад Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийт 3,161,776.1 мянган төгрөгийн тавилга эл хогшил, тоног төхөөрөмж зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Тус газрын төсвийн шууд захирагчийн үүргийг даргын албан үүргийг **түр орлон гүйцэтгэгч** Б.Өнөболд 2022 оны 02 дугаар сараас хойш 3 дахь жилдээ гүйцэтгэж, төсөв хөрөнгийг захиран зарцуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 345 дугаар тогтоолоор баталсан “Гаалийн улсын байцаагчид шагнал олгох журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	555,039,403.60	645,706,187.13
35	БАРАА МАТЕРИАЛ	555,039,403.60	645,706,187.13
35100	Түүхий эд материал	228,661,751.40	284,946,850.41
35110	Тусгай зориулалттай материал	186,588,181.40	249,708,880.41
35130	Эм боох материал	42,073,570.00	35,237,970.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11,514,396.80	5,991,670.00
35400	Хангамжийн материал	314,863,255.40	354,767,666.72
35410	Бичиг хэргийн материал	8,018,750.00	10,036,406.00
35420	Аж ахуйн материал	71,534,736.00	54,182,254.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,077,000.00	5,342,700.00
35440	Түлш, шатах тослох материал	18,725,320.00	25,344,170.00
35470	Бусад хангамжийн материал	213,507,449.40	259,862,136.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,134,175,468.69	17,972,572,119.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,134,175,468.69	17,972,572,119.46
39200	Биет хөрөнгө	12,134,511,532.19	14,574,155,382.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,328,739,723.03	10,401,049,673.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-905,863,224.85	-1,197,982,182.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	514,212,170.00	871,212,170.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-370,275,107.56	-419,522,554.66
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	13,814,507,499.47	15,757,162,758.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,791,264,277.10	-12,397,467,252.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	244,086,346.00	1,294,376,762.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	-77,154,511.07	-126,411,369.59
39214	Бусад үндсэн хөрөнгө	471,873,414.41	508,490,661.35
39215	Хуримтлагдсан элэгдэл	-96,165,137.86	-118,567,920.74
39217	Ном	1,814,637.72	1,814,637.72
39300	Биет бус хөрөнгө	2,999,663,936.50	3,398,416,736.50
39301	Программ хангамж	4,160,000.00	4,160,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,145,000.00	-2,827,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,076,206,386.62	3,475,641,686.62
39304	Хуримтлагдсан элэгдэл	-78,557,450.12	-78,557,450.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,689,214,872.29	18,618,278,306.59
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,689,214,872.29	18,618,278,306.59
51	Засгийн газрын хувь оролцоо	15,689,214,872.29	18,618,278,306.59
51100	Засгийн газрын оруулсан капитал	10,545,993,603.22	10,545,993,603.22
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	10,545,993,603.22	10,545,993,603.22
51200	Хуримтлагдсан үр дүн	4,121,414,654.96	7,050,478,089.26
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,532,613,583.15	4,121,414,654.96
51220	Тайлант үеийн үр дүн	6,654,028,238.11	2,929,063,434.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,021,806,614.11	1,021,806,614.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,689,214,872.29	18,618,278,306.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,144,670,462.34	15,156,337,405.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,185,475,898.34	4,475,179,621.48
120	Нийтлэг татварын бус орлого	7,185,475,898.34	4,475,179,621.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,944,819.00	26,546,845.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,019,193,213.34	73,320,866.32
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	144,337,866.00	4,375,311,910.16
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,959,194,564.00	10,681,157,784.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,959,194,564.00	10,681,157,784.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,959,194,564.00	10,681,157,784.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,490,642,224.23	11,749,388,566.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,490,642,224.23	11,749,388,566.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,339,378,712.51	9,978,673,063.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,183,197,038.26	6,802,717,118.38
210101	Үндсэн цалин	2,216,871,058.26	3,257,424,677.44
210102	Нэмэгдэл	1,263,629,275.00	1,855,703,424.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	241,696,000.00	869,718,500.00
210104	Урамшуулал	461,000,705.00	819,870,516.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	542,939,754.21	875,278,297.05
210201	Тэтгэврийн даатгал	374,298,600.99	595,104,146.78
210202	Тэтгэмжийн даатгал	43,304,251.01	70,042,386.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	33,364,813.46	43,363,290.71
210204	Ажилгүйдлийн даатгал	8,228,099.08	33,355,120.50
210205	Эрүүл мэндийн даатгал	83,743,989.67	133,413,352.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	338,637,103.79	491,326,116.61
210301	Гэрэл, цахилгаан	158,923,618.79	234,025,099.94
210302	Түлш, халаалт	156,612,904.00	240,333,076.67
210303	Цэвэр, бохир ус	23,100,581.00	16,967,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	119,346,436.21	167,070,925.00
210401	Бичиг хэрэг	21,961,540.00	26,473,340.00
210402	Тээвэр, шатахуун	38,314,000.00	61,651,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,537,442.26	2,172,337.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,277,253.95	3,104,204.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,026,200.00	48,313,500.00
210408	Бараа материал акталсны зардал	230,000.00	25,356,544.00
2105	Нормативт зардал	109,345,575.06	58,669,990.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103,140,575.06	51,380,240.99
210502	Хоол, хүнс	6,205,000.00	7,289,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	275,870,406.00	193,516,217.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,836,000.00	20,379,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	72,693,776.00	16,621,312.00
210604	Урсгал засвар	201,340,630.00	156,515,505.00
2107	Томилолт, зочны зардал	1,306,000.00	6,234,953.00
210702	Дотоод албан томилолт	1,306,000.00	6,234,953.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,264,325.91	236,985,540.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,617,776.51	166,122,560.00

210803	Даатгалын үйлчилгээ	2,699,837.00	2,463,887.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	510,925.00	485,025.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	242,000.00	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,603,800.00	3,348,000.00
210807	Газрын төлбөр	103,349.00	43,957.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	62,486,638.40	64,225,111.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	570,472,073.07	1,146,873,904.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,581,460.00	11,850,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	567,890,613.07	1,135,023,404.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,263,511.72	1,770,715,502.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	240,068,000.00	902,979,784.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	69,722,464.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	833,257,320.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,068,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	911,195,511.72	867,735,718.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	911,195,511.72	867,735,718.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,654,028,238.11	3,406,948,838.96
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	477,885,404.66
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	477,885,404.66
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	-477,885,404.66
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	6,654,028,238.11	2,929,063,434.30

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,981,139,383.00	10,707,678,409.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,944,819.00	26,520,625.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,944,819.00	26,520,625.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,944,819.00	26,520,625.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,944,819.00	26,520,625.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,959,194,564.00	10,681,157,784.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,959,194,564.00	10,681,157,784.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,959,194,564.00	10,681,157,784.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,886,277,193.00	10,631,849,859.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,886,277,193.00	10,631,849,859.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,735,013,681.28	8,861,134,356.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,183,172,433.26	6,803,683,538.38
210101	Үндсэн цалин	2,216,846,453.26	3,258,296,057.44
210102	Нэмэгдэл	1,263,629,275.00	1,855,798,464.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	241,696,000.00	869,718,500.00
210104	Урамшуулал	461,000,705.00	819,870,516.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	542,939,754.21	874,285,657.05
210201	Тэтгэврийн даатгал	374,298,600.99	594,206,546.78
210202	Тэтгэмжийн даатгал	43,304,251.01	69,947,346.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	33,364,813.46	43,363,290.71
210204	Ажилгүйдлийн даатгал	8,228,099.08	33,355,120.50
210205	Эрүүл мэндийн даатгал	83,743,989.67	133,413,352.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	335,172,063.79	495,599,966.61
210301	Гэрэл, цахилгаан	158,923,618.79	234,025,099.94
210302	Түлш, халаалт	155,002,864.00	237,751,926.67
210303	Цэвэр, бохир ус	21,245,581.00	23,822,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	125,768,283.21	168,096,477.00
210401	Бичиг хэрэг	22,318,940.00	27,842,780.00
210402	Тээвэр, шатахуун	36,000,000.00	62,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,537,442.26	2,172,337.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,277,253.95	3,104,204.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	57,634,647.00	72,977,156.00
2105	Нормативт зардал	93,697,060.00	78,921,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	87,492,060.00	71,631,870.00
210502	Хоол, хүнс	6,205,000.00	7,289,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	266,225,939.30	196,707,255.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	37,511,000.00	28,187,650.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	22,380,000.00	12,004,100.00
210604	Урсгал засвар	206,334,939.30	156,515,505.00
2107	Томилолт, зочны зардал	1,306,000.00	6,234,953.00
210702	Дотоод албан томилолт	1,306,000.00	6,234,953.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	184,150,687.51	225,754,389.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,617,776.51	166,122,560.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,699,837.00	2,463,887.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	510,925.00	485,025.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	242,000.00	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,018,800.00	3,348,000.00
210807	Газрын төлбөр	103,349.00	43,957.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	47,958,000.00	52,993,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,581,460.00	11,850,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,581,460.00	11,850,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,263,511.72	1,770,715,502.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	240,068,000.00	902,979,784.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	69,722,464.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	833,257,320.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,068,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	911,195,511.72	867,735,718.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	911,195,511.72	867,735,718.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	94,862,190.00	75,828,550.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	94,862,190.00	75,828,550.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	94,862,190.00	75,828,550.00
2200	Дотоод эх үүсвэрээр	94,862,190.00	75,828,550.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	94,862,190.00	75,828,550.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-94,862,190.00	-75,828,550.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,545,993,603.22	1,021,806,614.11	-2,532,613,583.15	9,035,186,634.18
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,545,993,603.22	1,021,806,614.11	-2,532,613,583.15	9,035,186,634.18
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,654,028,238.11	6,654,028,238.11
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,545,993,603.22	1,021,806,614.11	4,121,414,654.96	15,689,214,872.29
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,545,993,603.22	1,021,806,614.11	4,121,414,654.96	15,689,214,872.29
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,929,063,434.30	2,929,063,434.30
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,545,993,603.22	1,021,806,614.11	7,050,478,089.26	18,618,278,306.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,873,844,000.00	9,839,942,690.04	1,033,901,309.96	90.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,873,844,000.00	9,839,942,690.04	1,033,901,309.96	90.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,793,844,000.00	8,936,962,906.04	856,881,093.96	91.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,346,328,000.00	6,803,683,538.38	542,644,461.62	92.61
210101	Үндсэн цалин	3,411,600,000.00	3,258,296,057.44	153,303,942.56	95.51
210102	Нэмэгдэл	2,048,000,000.00	1,855,798,464.94	192,201,535.06	90.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,040,728,000.00	869,718,500.00	171,009,500.00	83.57
210104	Урамшуулал	846,000,000.00	819,870,516.00	26,129,484.00	96.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,036,291,000.00	874,285,657.05	162,005,342.95	84.37
210201	Тэтгэврийн даатгал	714,117,800.00	594,206,546.78	119,911,253.22	83.21
210202	Тэтгэмжийн даатгал	92,293,300.00	69,947,346.60	22,345,953.40	75.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	54,396,600.00	43,363,290.71	11,033,309.29	79.72
210204	Ажилгүйдлийн даатгал	34,396,700.00	33,355,120.50	1,041,579.50	96.97
210205	Эрүүл мэндийн даатгал	141,086,600.00	133,413,352.46	7,673,247.54	94.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	611,000,000.00	495,599,966.61	115,400,033.39	81.11
210301	Гэрэл, цахилгаан	320,000,000.00	234,025,099.94	85,974,900.06	73.13
210302	Түлш, халаалт	256,000,000.00	237,751,926.67	18,248,073.33	92.87
210303	Цэвэр, бохир ус	35,000,000.00	23,822,940.00	11,177,060.00	68.07
2104	Хангамж, бараа материалын зардал	170,600,000.00	168,096,477.00	2,503,523.00	98.53
210401	Бичиг хэрэг	28,000,000.00	27,842,780.00	157,220.00	99.44
210402	Тээвэр, шатахуун	62,000,000.00	62,000,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	2,172,337.00	1,827,663.00	54.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,600,000.00	3,104,204.00	495,796.00	86.23
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,000,000.00	72,977,156.00	22,844.00	99.97
2105	Нормативт зардал	87,300,000.00	78,921,620.00	8,378,380.00	90.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,000,000.00	71,631,870.00	8,368,130.00	89.54
210502	Хоол, хүнс	7,300,000.00	7,289,750.00	10,250.00	99.86
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	278,800,000.00	272,535,805.00	6,264,195.00	97.75
210601	Багаж, техник, хэрэгсэл	88,000,000.00	82,807,250.00	5,192,750.00	94.10
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,000,000.00	12,004,100.00	995,900.00	92.34
210604	Урсгал засвар	177,800,000.00	177,724,455.00	75,545.00	99.96
2107	Томилолт, зочны зардал	19,300,000.00	6,234,953.00	13,065,047.00	32.31
210702	Дотоод албан томилолт	19,300,000.00	6,234,953.00	13,065,047.00	32.31
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	229,875,000.00	225,754,389.00	4,120,611.00	98.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	168,000,000.00	166,122,560.00	1,877,440.00	98.88

	үйлчилгээний төлбөр хураамж				
210803	Даатгалын үйлчилгээ	2,700,000.00	2,463,887.00	236,113.00	91.26
210804	Тээврийн хэрэгслийн татвар	800,000.00	485,025.00	314,975.00	60.63
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	300,000.00	297,000.00	3,000.00	99.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,775,000.00	3,348,000.00	1,427,000.00	70.12
210807	Газрын төлбөр	300,000.00	43,957.00	256,043.00	14.65
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	53,000,000.00	52,993,960.00	6,040.00	99.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,350,000.00	11,850,500.00	2,499,500.00	82.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,350,000.00	11,850,500.00	2,499,500.00	82.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,080,000,000.00	902,979,784.00	177,020,216.00	83.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,080,000,000.00	902,979,784.00	177,020,216.00	83.61
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	160,000,000.00	69,722,464.00	90,277,536.00	43.58
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	920,000,000.00	833,257,320.00	86,742,680.00	90.57
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,873,844,000.00	10,707,678,409.00	166,165,591.00	98.47
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,858,178,000.00	10,681,157,784.00	177,020,216.00	98.37
310001	Улсын төсвөөс санхүүжих	10,858,178,000.00	10,681,157,784.00	177,020,216.00	98.37
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,666,000.00	26,520,625.00	-10,854,625.00	169.29
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,666,000.00	26,520,625.00	-10,854,625.00	169.29

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ГЕГ-ын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар /цаашид Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар гэх/ нь “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд оршино” гэж зорилгоо тодорхойлон үйл ажиллагаа явуулсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих,
- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих,
- Гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих,
- Гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах,
- Гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах,
- Гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах,
- Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх,
- Гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх,
- Гаалийн тухай хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд,
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 12 дугаар сарын 12-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд ГЕГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгөгдсөн байна.

Мөн Сангийн яамны удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн бөгөөд ур чадварын нэмэгдэл болон цахим төлбөрийн баримт, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ГЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/272 дугаар тушаалаар ГЕГ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Уг баримт бичгийг баталсан 2019 оноос хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлийг тусган Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,929,063.4 мянган төгрөгөөр буюу 18.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	555,039.40	645,706.19	90,666.79
Үндсэн хөрөнгө	15,134,175.50	17,972,572.12	2,838,396.62
Нийт хөрөнгө	15,689,214.90	18,618,278.31	2,929,063.41
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	15,689,214.90	18,618,278.31	2,929,063.41
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,689,214.90	18,618,278.31	2,929,063.41

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 645,706.2 мянган төгрөг болж 90,666.8 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 603,321.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- ГЕГ-аас 55,279.2 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Шатахууны урамшуулалд 1,996.0 мянган төгрөгийн шатахууны талон хүлээн авсан,
- 2023 оны 12 дугаар сард актлагдсан үндсэн хөрөнгөөс тус газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/13 дугаар тушаалаар 11 төрлийн 16,045.7 мянган төгрөгийг дахин үнэлж орлогод авсан,
- ГЕГ-т 165.0 мянган төгрөгийн /тоон гарын үсгийн/ бараа материалыг шилжүүлсэн,
- ТӨБЗГ-ын зөвшөөрлөөр 25,356.5 мянган төгрөгийн бараа материал акталсан,
- Үйл ажиллагаанд 560,454.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,972,572.1 мянган төгрөг болж 2,838,396.6 мянган төгрөгөөр өссөн нь:

- ГЕГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/388 дугаар тушаалаар Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хүрээнд нийт 3,149,647.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан,
- ГЕГ-аас нийт 1,211,129.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бол,
- ГЕГ-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/531 дүгээр тушаалаар 562,645.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлсэн,
- ТӨБЗГ-ын 2024 оны 817 дугаар тогтоолоор 112,551.4 мянган төгрөгийн бараа материал акталсан зэргээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 10,227,563.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,666.7 мянган төгрөг, нийт зарлагыг 10,229,230.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 1,585,786.2 мянган төгрөгөөр бууруулж 8,643,444.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 992,681.3 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 88,068.7 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 101,483.2 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 147,082.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 168,796.9 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 43,800.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг улсын төсвөөс 10,858,178.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 15,666.0 мянган төгрөг зэрэг нийт 2,230,400.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 643,375.0 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 89,000.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 242,800.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 113,775.0 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 1,080,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 10,858,178.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 15,666.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 10,681,157.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 26,520.6 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9,839,942.7 мянган төгрөг буюу 90.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 856,086.5 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	9,634,044.00	8,777,957.45	856,086.55	91.1

2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	50,000.00	49,739.46	260.54	99.5
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	200.00	200.00	0.00	100.0
4	Харуул, хамгаалалтын зардал	91,800.00	91,341.00	459.00	99.5
5	Холбооны суваг ашигласны хөлс	7,800.00	7,800.00	0.00	100.0
6	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	10,000.00	9,925.00	75.00	99.3
7	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,080,000.00	902,979.78	177,020.22	83.6
	Дүн	10,873,844.00	9,839,942.69	1,033,901.31	90.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130435402 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/				
№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Харуул хамгаалалт	91,800.00	91,341.00	НТШ
2	Эм бэлдмэл	80,000.00	71,100.00	НТШ
3	Түлш халаалт	70,000.00	69,890.00	Харьцуулалтын арга
4	Шатахуун, шатах тослох материал	30,000.00	28,798.40	Харьцуулалтын арга
	Нийт дүн	271,800.00	261,129.40	

Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх тендерт Шүрэн-Үндэс ХХК, шил сав, туслах материал нийлүүлэх тендерт Лайфтроник ХХК /39,900.0 мянган төгрөгийн/, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерт Монбиофарм ХХК /11,750.0 мянган төгрөгийн/, ариутгалын бодис нийлүүлэхэд Реактив ХХК /тендерийг 6 удаа зарласан боловч оролцогч ирээгүйгээс 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 19,450.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан/, нүүрс нийлүүлэх тендерт Экопартнерс ХХК, шатахуун, шатах тослох материал нийлүүлэх тендерт НИК ХХК тус тус шалгарч, гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/39 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,490,642.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 74,906.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах төсвийг хэмнэж ажилласан байна. Үүнд:

- Албан хаагчидтай албаны цахим шуудангаар харьцаж, бичгийн цаасны болон шуудан үйлчилгээ, суурин утасны хэрэглээг бууруулж, хангамжийн материалын батлагдсан төсвийг 1,984.9 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг 7 автомашинд төрийн албаны цэнхэр дугаарыг хэрэглэж байна.
- Байгууллагын цэвэр бохир ус, дулаан, цахилгааны хэрэглээнд хэмнэлтийн горим хэрэгжүүлж, 115,400.0 мянган төгрөгийн төсвийг хэмнэсэн гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн тайланд шинжилгээ хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл болон шилэн данстай холбоотой зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2		2		100.0
Нийт дүн	2		2		100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **1,925.0** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өглөө. Үүнд:

1. Худалдаж авсан **1,925.0** мянган төгрөгийн хангамжийн материалыг орлого авалгүйгээр шууд зарлагаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, эрх зүйн актад нийцүүлэн хөтөлж байх, дээр алдааг 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх.

Аудитаар нийт **37,417.2** мянган төгрөгийн зөрчил² илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

5.1.1. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний /80103/ арга хэмжээний зардлаас үндсэн үйл ажиллагааны /80101/ зардалд нийт **17,417.2** мянган төгрөгийг арга хэмжээ хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Жилийн эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэлгүйгээр 2025 онд албан хаагчдыг усан спортын сургалтын төвд хичээллүүлэх зорилгоор гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний батлагдсан төсвөөс **20,000.0** мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн Биеийн тамир спортын газарт шилжүүлж, тайлант оны зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “*Төсвийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно*”, 7.7 дахь “... төсвийн захирагчийн ... төсвийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулагдаагүй үлдээгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн батлагдсан төсвөөс дараа оны үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх, төсвийн хэмнэлтийг жилийн эцэст татан төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Худалдан авсан хангамжийн материалыг шууд зарлагдсан	1	1,925.0			1	1,925.0			1	1,925.0	1	1,925.0
Дүн	1	1,925.0			1	1,925.0			1	1,925.0	1	1,925.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны	Тоо	Дүн
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	17,417.2			1	17,417.2						
Төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлээгүй	1	20,000.0			1	20,000.0						
Дүн	2	37,417.2			2	37,417.2						